



ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 3 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлыг тодорхойлох:
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаар санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 4: Менежментийн захидал

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Халамжийн сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2016/12-СТА-ЗГТС/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 3 дугаар сарын 05-наас 2016 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 1/198 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлснийг аудиторт 3 дугаар сарын 7-ны өдөр хүлээн авсан байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар /Халамжийн сан/ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар нь Засгийн газрын 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор байгуулагдсан. 9070003087 улсын бүртгэлийн дугаартай, 5635926 регистрийн дугаар бүхий 8790 кодтой, Хүн амын

хөгжлийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус ерөнхий газар нь 21 аймаг, 9 дүүргийн нийт 31 нэгжид Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулан ажилладаг Засгийн газрын тусгай сан юм.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын эрхэм зорилго нь Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, үйлчлүүлэгчдэд ёс зүйтэй мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх замаар тэдний тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авах, асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршдог.

Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын зорилт, чиг үүргийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүн амын хөгжлийг хангах дэмжих төрийн бодлогын хэрэгжилтийг хангах;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай хүнд сурталгүй чанартай хүргэх, халамж асрамжийн шинэ үйлчилгээ, менежментийг нэвтрүүлэх, ТББ болон хувийн хэвшлийн оролцоотойгоор үйлчилгээг чанартай хүргэх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын механизмыг боловсронгуй болгох;
- Төсвийн төлөвлөлтийн орон нутгийн хүн амын тоо, зорилтот бүлгийн иргэдийн тоотой уялдуулах, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна:

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д."Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн" гэж заасны дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Халамжийн сангийн 2015 оны төсвийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Халамжийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 5-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байгаа ч УСНББОУС, хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулах шаардлагатай байна.

Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий санхүү, нягтлан бодох бүртгэлийн "Account" санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлыг тодорхойлох:

Төсвийн тухайн хуулийн дагуу улсын төсвөөс санхүүждэг, Засгийн газрын тусгай сан учир материаллаг байдлын суурийг тайлант оны нийт зардлаар авч, түүний 1 хувиар тооцож, /35,513.3 сая төгрөгийн нэг хувь/= 355.1 сая төгрөгөөр тогтоосон.

Дотоод хяналт:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын баталсан удирдамжийн дагуу 2015 оны 02 дугаар сарын 09-нөөс ажлын 10 өдөрт багтаан аудитын шалгалтын хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитаар Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн данс тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, 2014 оны санхүүгийн тайлан тэнцэл, төсөв төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, тушаал, журам, албан хэрэг хөтлөлтийн стандарт зэргийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгч, 4 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч ХАХНХЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын Дотоод аудитын албанд холбогдох тайлбар, баримтын хамт хүргүүлж ажилласан байна.

Тус газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар харъяа аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна. Нийт 29 нэгжид давхардсан тоогоор 213 заалт бүхий 23 зөвлөмжийг хүргүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Халамжийн сангийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Халамжийн сангийн төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс 35,352.8 сая, банкны чөлөөт үлдэгдлийн хүү болон бусад орлого 122.8 сая, нийт 35,475.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр халамжийн санд 36,729.4 сая төгрөгний санхүүжилт батлагдсанаас 34,157.6 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 2,571.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар нь 2014-2016 онд “ Шилэн данс”, “Шилэн тендер”-ийг санхүүгийн болон байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зорилт тавьж амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 26 дугаар хуулийн дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 205 дугаар тушаал батлагдан холбогдох журам, заавар, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- Тус байгууллага halamj.gov.mn вэб сайтад халамжийн сар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан болон холбогдох бусад санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж хэвшүүлэн ажилласан.
- Байгууллагын цахим хуудсаны ил тод байдал цэсэнд санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол байршуулснаар олон нийт халамжийн сангийн төсвийн зарцуулалт болон түүний үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх.
- Shilendans.gov.mn сайтад хуулинд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь шинэчлэн байршуулж хуулийг хэрэгжүүлэн ажиллах.
- Шинээр мэдээллийн самбарыг хийлгэж байгууллагын 4 давхарт байршуулан санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан түүнд байгууллагын удирдлагууд хяналт тавьж, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар иргэд, хэрэглэгчийг үнэн зөв, бодит мэдээлэлийг хүргэж, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн

бүхий дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, 21 аймаг, 9 дүүргийн халамжийн сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад нийт 31 байгууллага хамрагдаж 52.1 хувь буюу 18 нэгжийг аймгийн Аудитын газрууд, 44.9 хувь буюу 12 нэгжийг аудитын компаниуд гэрээлэн аудит хийж дүгнэлт гаргасан байна. Баян-өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс “Хязгаарлалтай” санал дүгнэлт авч, бусад байгууллагууд зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Аудитын явцад Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлан гаргалтын талаар:

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

2015 оны санхүүгийн тайлангаар 130.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 0.5 сая төгрөгийн авлага, 106.3 сая төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөг, 25.0 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төсвийн санхүүжилтийн талаар:

2015 онд халамжийн санд улсын төсвөөс алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох 29,159.8 сая, ахмад дайчид, алдар цолтон ахмад настны хөнгөлөлт олгох 5,174.9 сая, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ 110.9 сая халамжийн үйл ажиллагааны зардалд 437.4 сая, бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг үйлчилгээний зардал 469.6 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулалтын эрх нээлгэн 21 аймаг 9 дүүрэг хуваарилан зарцуулсан байна.

Халамжийн сангийн зарцуулалт :

Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж: 2015 онд аймаг дүүргүүдийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүдээр дамжуулан нийт 208,670 эхэд 28,279.6 сая, өмнөх оны олгогдоогүй тэтгэмж болох өглөгөөс 82.7 сая, ахмад дайчид болон алдар цолтон ахмадуудад олгох хөнгөлөлт нийт 4,790 хүнд 4,923.3 сая төгрөг өмнөх оны олгогдоогүй тэтгэмж болох өглөгөөс 38.8 сая төгрөг, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд 109,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дахин үнэлгээ хийх зардал 364.8 сая, дахин үнэлгээний томилолт 14.7 сая, санхүүгийн дэмжлэг 81.5 сая, Буриад улсын Нийгмийн хамгааллын сайдыг хүлээн авах зардал 5.3 сая, чуулганы шууд дамжуулалтын төлбөр 2.0 сая, барааны үнэ, бичиг хэргийн зардалд 1.3 сая, нийт 469.6 сая төгрөг бусдаар гүйцэтгүүлэх нийтлэн бараа ажил үйлчилгээний зардлаар тайлагнасан.

Улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардал 103.0 сая, томилолтын зардал 108.8 сая, ХҮМ-програмын шинэчлэлийн шаталсан сургалтын зардал 55.4 сая, санхүүгийн дэмжлэг 42.7 сая, гэрээгээр 28.2 сая, семинарын зардал 8.7 сая, сургалтын байрны түрээс 8.6 сая, сургалтын цайны зардалд 6.5 сая, сургалтын гарын авлага 2.7 сая, үйлчилгээний төлбөр 1.9 сая, барааны үнэ, бичиг хэргийн зардалд 0.9 сая, багшийн хөлс 0.1 сая, нийт 367.5 сая төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаар тайлагнасан.

Авлагын талаар:

2015 онд Хан-уул дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс илүү олгосон 490.0 мянган төгрөгийг авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Өглөгийн талаар:

Өглөгийн тодруулгаар 2015 онд оны эхний өглөгөөс 121.6 сая төгрөг төлөгдөж, тайлант оны эцэст 106.3 сая төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илэрсэнгүй.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. 2015 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр 1/198 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна. Тус санхүүгийн тайланд байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн томоохон үйл явдлын тухай тодруулга, тайлбар ирүүлээгүй байгаа нь УСНББОУС-1 стандартын санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд хавсралт А-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлого түүний чанарын шинж төрх байдлыг багтаасан байгууллагын мэдээллийг танилцуулах шаардлагыг энэ стандартын 29 дүгээр зүйлд тусгасан”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын “төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн нүүрний хэсэгт харуулсан дүнгүүдийн талаар хүүрнэсэн тодорхойлолт, эсвэл нилээд дэлгэрэнгүй жагсаалт буюу судалгаа, мөн болзошгүй өр төлбөр болон амлалт гэх мэт нэмэлт мэдээллийг багтаана” 8.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.;

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-1 стандарт болон Сангийн сайдын 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 1.8 сая төгрөгийн 39 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Зөвлөмж

Халамжийн сангийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлагналын талаар нэг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халамжийн сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд.... хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.



ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

Менежментийн захидал

Асуудал 1 Санхүүгийн тайлагналын
талаар

2016 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Халамжийн сангийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан болно. Энэ нь Халамжийн сангийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын Санхүү бүртгэл, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Гандолгор санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

2015 оны санхүүгийн тайлангаа 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдөр 1/198 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна. Тус санхүүгийн тайланд байгууллагын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлсэн томоохон үйл явдлын тухай тодруулга, тайлбар ирүүлээгүй байгаа нь УСНББОУС-1 стандартын санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд хавсралт А-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлого түүний чанарын шинж төрх байдлыг багтаасан байгууллагын мэдээллийг танилцуулах шаардлагыг энэ стандартын 29 дүгээр зүйлд тусгасан”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын “төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга нь .санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлангийн нүүрний хэсэгт харуулсан дүнгүүдийн талаар хүүрнэсэн тодорхойлолт, эсвэл нилээд дэлгэрэнгүй жагсаалт буюу судалгаа, мөн болзошгүй өр төлбөр болон амлалт гэх мэт нэмэлт мэдээллийг багтаана” 8.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.;

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн иж бүрдэл хангагдахгүй байх, буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС-1 стандарт болон Сангийн сайдын 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ТУВААН
ТАНАА

2016.03.25 № 3/549
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Халамжийн сангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0325SAG19.Docx

070518

7XA0122

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

/төгрөгөөр/

Дансн ы код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	183,787,904.36	130,844,992.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	183,787,904.36	130,844,992.62
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	183,787,904.36	130,844,992.62
31210	Төгрөг	183,787,904.36	130,844,992.62
31211	Төрийн сангийн харилцах	183,787,904.36	130,844,992.62
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	183,787,904.36	130,844,992.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	183,676,234.92	106,353,763.48
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	183,676,234.92	106,353,763.48
41300	Өглөг	183,676,234.92	106,353,763.48
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	183,676,234.92	106,353,763.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	109,669.44	24,981,229.14
51	Засгийн газрын хувь оролцоо	109,669.44	24,981,229.14
51200	Хуримтлагдсан үр дүн	109,669.44	24,981,229.14
51210	Өмнөх үеийн үр дүн		62,168,196.82
51220	Тайлант үеийн үр дүн	109,669.44	(37,186,967.68)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	183,785,904.36	131,334,992.62

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /улсын/	35,153,533,444.00	35,352,801,750.00
	Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсаны жүгийн орлого	56,380,728.06	122,807,283.90
	Бусад эх үүсвэр	17,857,668.77	490,000.00
	Татаас ба санхүүжилтийн орлого	35,227,771,840.83	35,476,099,033.90
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	84,000,000.00	109,932,500.00
	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	5,000,623,956.24	4,963,985,619.70
	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,477,123,664.73	28,345,386,661.25
	Банкны үйлчилгээний шимтгэл	6,294,286.71	7,568,874.23
	Халамжийн үйл ажиллагааны зардал	495,938,783.00	367,495,237.00
	Бусдаар гүйцэтгэх нийтлэг ажил үйлчилгээ		469,606,833.00
	Сангийн үйл ажиллагааны зардлын дүн	34,063,980,690.68	34,263,975,725.18
	Төсөвт төвлөрүүлэх	1,163,681,480.71	1,249,310,276.40
	Сангийн нийт зардал	35,227,662,171.39	35,513,286,001.58
	Тайлант үеийн үр дүн	109,669.44	(37,186,967.68)

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН М ӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /улсын/	35,153,533,444.00	35,352,801,750.00
	Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсаны хүүгийн орлого	56,380,728.06	122,807,283.90
	Бусад эх үүсвэр	17,857,668.77	
	Татаас ба санхүүжилтийн орлого	35,227,771,840.83	35,475,609,033.90
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	84,000,000.00	109,932,500.00
	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	4,948,621,846.50	4,923,364,230.46
	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,349,289,187.15	28,279,654,287.01
	Банкны үйлчилгээний шимтгэл	6,294,286.71	7,568,874.23
	Халамжийн үйл ажиллагааны зардал	495,938,783.00	367,495,237.00
	Бусдаар гүйцэтгэх нийтлэг ажил үйлчилгээ		469,606,833.00
	Сангийн үйл ажиллагааны зардлын дүн	33,884,144,103.36	34,157,621,961.70
	Төсөвт төвлөрүүлэх	1,168,958,670.54	1,249,310,276.40
	Урьд оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт	188,650,763.72	121,619,707.54
	Сангийн нийт зардал	35,241,753,537.62	35,528,551,945.64
	Тайлант үеийн үр дүн	(13,981,696.79)	(52,942,911.74)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,769,601.15	183,787,904.36
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	183,787,904.36	130,844,992.62
		(13,981,696.79)	(52,942,911.74)

СТ-4А

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			62,168,196.82		62,168,196.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	62,168,196.82	-	62,168,196.82
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
7	Тайлант үеийн үр дүн					-
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	62,168,196.82	-	62,168,196.82
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	62,168,196.82	-	62,168,196.82
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
15	Тайлант үеийн үр дүн			(37,186,967.68)		(37,186,967.68)
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	24,981,229.14	-	24,981,229.14

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2015 ОНЫ АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		183,787,904.36		
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	138,260,000.00	109,932,500.00	(28,327,500.00)	79.5
Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	6,184,200,000.00	4,924,480,854.69	(1,259,719,145.31)	79.6
Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	29,449,000,000.00	28,286,106,537.01	(1,162,893,462.99)	96.1
Хичээл үйлдвэрлэлийн зардал	287,100,000.00	264,525,237.00	(22,574,763.00)	92.1
Бусдаар гүйцэтгэх нийтлэг ажил үйлчилгээ	470,900,000.00	469,606,833.00	(1,293,167.00)	99.7
Улсын мэдээллийн маягт бэлтгэх	200,000,000.00	102,970,000.00	(97,030,000.00)	51.5
Сангийн үйл ажиллагааны зардлын дүн	36,729,460,000.00	34,157,621,961.70	(2,571,838,038.30)	93.0
Санхүүжүүлэх эх үүсвэр	36,729,046,000.00	34,202,141,933.29	(2,526,904,066.71)	93.1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /улсын/	36,729,046,000.00	34,202,141,933.29	(2,526,904,066.71)	93.1
Сангийн чөлөөт үлдэгдлийн банкны хүү			-	
Бусад орлогоос			-	
Тохируулгын дүн		97,462,883.33		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		130,844,992.62		